



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

“Мал аж ахуйн тогтвортой хөгжил” малчдын улсын зөвлөгөөн

Бэлчээрийн ашигласны төлбөрийн талаар

НҮБХХ-н “Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга” төслийн хүрээнд
боловсруулсан санал

Бодлого судлалын төв /www.cpr.mn /

Тэргүүн доктор А.Энх-Амгалан

Улаанбаатар хот

2018 оны 5-р сарын 17

Малчины амьжиргааны арга, түүнийг нөхцөлдүүлэгч хүчин зүйлс:

Нөхцөл байдалдаа тохируулан хамгийн хямд аргаар хөрөнгө, орлогоо нэмэгдүүлэх гэж өрсөлдөн уралдах нь зах зээлийн эдийн засгийн зарчим

Малчинд үйлчилж байгаа сонирхлын өнөөгийн механизм?

- ▶ Бэлчээр, түүн дээр байгаа ус, хужир мараа гээд аливаа нөөцийг үнэ төлбөргүй ашигладгийн зэрэгцээ даацыг нь хэтрүүлж талхалсан ч ямар ч хариуцлага хүлээдэггүй нийтээр дундаа ашигладаг тогтолцоо

Үр дагавар?



Ж:1980-аад оны сүүлээр 1 хонин толгойд 20 кг т.н бэлтгэж байсан бол 2016 онд 6.2 кг болж, 3 дахин буурсан

Үр дагавар?

- Малын тоог өсгөсний шууд үр дагавар нь бэлчээр доройтож, малын чанар, ашиг шим буурч, эрсдэлд өртөмхий болж, малчдын хөрөнгө, орлого багасаж буйгаар илэрч байна. Доройтсон бэлчээрийг соргог бэлчээртэй харьцуулбал эм хонины хаврын амьдын жин 8 кг-аар, сүүний гарц 2.5 дахин, ямааны ноолуурын гарц 8%-р бага байна. Энэ 3 үзүүлэлтээр тооцоход малчин өрхийн орлогын алдагдал жилдээ 2.6 сая, улсын хэмжээнд 368 тэрбум төгрөг болж байна.
- Мал, махны эрүүл байх чанар алдагдсанаас экспортод гаргаж чадахаа байсан
- Монгол малын үндсэн давуу тал болсон экологийн цэвэр байдалд сөргөөр нөлөөлсөн.
- Хамгийн гол нь МАА-н үндэс болсон бэлчээрийн доройтол мөнгөөр үнэлшгүй хохирол учруулж байна. Бэлчээрийн 65% талхлагдаж, 7% эргэж сэргэхээргүй доройтсон- 1 аймгийн нутаг алдагдсан

МАА-Н ХӨГЖИЛ



2014 оноос хойш малын тоо 27%-р өссөн боловч малын үнэ цэнэ 37%-р унаж дүнгээрээ малчдын үндсэн хөрөнгө - 10% алдагдал хүлээгээд байна!!!

Гол асуулт?

- Жалгын нэг тарж, малаа өсгөх гэж хоёр зудын хооронд гадаа гандаж, хөдөө хөхрөөд үр дүнд нь хожсон зүйлгүй, харин ч бэлчээрээ талхалж, дээр нь отрын бэлчээрээ үгүй хийснээс дараагийн ган, зудаар бүр ч илүү хохирдог чөтгөрийн тойргоос малчдыг гаргаж, амьдралд нь наалдахгүй байгаа тооны хөөсийг өөрчлөхөд юу хэрэгтэй вэ?
- Малчин хүнийг аж ахуйдаа дэвшилтэт арга нэвтрүүлэх сонирхолгүй болгож, МАА-н хөгжлийг ухраагаад байгаа сонирхлын механизмыг нь яаж өөрчлөх вэ?

Цаашдаа яах вэ?

МАН-н үйлдвэрлэлийн зардал нь тухайн малчин өрхийн өөрийн гаргасан хүн хүч, тэжээл, эм тарилга, тээвэр гэх мэт "дотоод" зардал, "гадаад" зардлын нийлбэрээс бүтнэ. Гадаад зардал нь бэлчээрийг ашигласны болон түүнд хор хохирол учруулсан бол тэр хохирлын хэмжээгээр нийгэмд учирч байгаа зардал юм. Гадаад зардлыг малчин үүрэхгүй байгаа учраас ямар хэмжээтэй гарах нь сонирхлыг нь нэг их татахгүй.

Энэхүү гадаад зардлыг малчны сонирхлын хүрээнд хэрхэн оруулж ирж:

Бэлчээртээ өөриймсөг ханддаг

Даацыг нь хэтрүүлж талхалсан бол эдийн засгийн хариуцлага хүлээдэг

Ингэснээр малын тоог өсгөх биш харин, чанар, бүтээмжийг сонирхдог болгох вэ гэдэгт асуудлын гол оршиж байна.

ҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГ ГОЛ МЕХАНИЗМ НЬ БЭЛЧЭЭРИЙН ТӨЛБӨР ЮМ.

Бэлчээрийн төлбөр тогтооход баримтлах зарчим:

1. Малын тоог бэлчээрийн даацтай шууд уялдуулах
2. Малаа чанаржуулж, борлуулалтыг нэмэгдүүлэх- **хөшүүрэг**
3. Орон нутагт санхүүжилтийн бие даасан эх үүсвэрийг бүрдүүлж, бэлчээр, МАА-н эрсдэл, байгаль хамгаалах ажлыг малчдын оролцоотойгоор төлөвлөж, хэрэгжүүлэх **механизм**
4. Гамшгийн үед хэрэгдэх сантай болсноор орон нутаг төр засгаа хардаг, төр засаг нь гаднаас хандив, тусламж хайдаг, цагт хавчигдан түүнийг үр ашиг муутай зарцуулдаг тогтолцоог **өөрчлөх арга**
5. Малчдад санхүүгийн дарамт болохооргүй байх

Хэрэгжилт:

- Орон нутагт олдоцтой, ойлгомжтой тоон үзүүлэлт болох бэлчээрийн га-н ургац дээр суурилан чанарын ялгааг гаргасан
- Бэлчээрийн даац хэтрэлтийг ашиглагчийн түвшинд тооцсоноор сайн, муу ашиглагчид ялгавартай хандах урамшууллын механизм болсон
- Малын төрөл -ямаа, адуунд ахиу, үхэр, тэмээнд доогуур төлбөр ноогдуулсан /1 хонин толгой- адуу 8, ямаа 2, үхэр 4, тэмээ 3/
- Байршлын ялгаа-хот, суурин орчим өндөр, алсагдсан нутагт бага
- Бэлчээр, эрсдэл, байгаль орчны менежментийг малчдын оролцоотойгоор хэрэгжүүлэх төсвийн хэрэгцээг харгалзсан
- Малчид, нэн ялангуяа ядуу малчдад санхүүгийн дарамт болохооргүй механизмыг бүрдүүлсэн
- Урьд нь хэд хэдэн аймаг, сумдад туршсан үр дүн, орон нутгийн хэлэлцүүлэгт тулгуурласан

Төлбөр тооцох, орлогыг хуваарилах арга

Төлбөрийг урьд жилийн эцсийн малын тоонд үндэслэж, $1/VI$ -с өмнө авна.

Малчид төлбөрийг орлогоос ашиг хүртэх нөхцөл:

- ▶ Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах буюу байгуулаагүй ч ашиглалтын хил заагаа тодорхойлж, бэлчээрийн даац хэтэрсэн эсэхийг тооцох боломжтой болгосон байна.

Бэлчээрийн төлбөрийг эргүүлээд яаж зарцуулах вэ?

МАА-н эрсдэлийн сан /МААЭС/- малчдаас ирүүлэх бэлчээр, эрсдэл, байглаь хамгаалах төслийг гэрээгээр санхүүжүүлнэ

- ▶ Малыг чанарын урамшууллын сан /МЧУС/- чанарын шаардлага хангаж, зах зээлд нийлүүлсэн малын толгой дутамд: 1 х/т 2000-2600 төг, түүнээс их

Үр дүн: Орлогын хуваарилалт, дундаж сумын жишээ

	Өндөр уул	Ойт хээр	Хээр	Говь	Их хотгор нуурын
Төлбөрийн орлого, сая төг	323	305	334	283	289
Зарцуулалт, сая төг:					
Сумын мэдэлд үлдэх	52	50	59	48	47
МААЭС-с малчдад олгох	140	134	159	129	126
МЧУС-с малчдад олгох	131	121	116	106	116
Дундаж малчин өрхийн тооцоо, мянган төг					
Бэлчээрийн төлбөр төлөх	524	603	739	644	716
Буцаагаад ашиг хүртэх	440	505	607	536	600
1 хонин толгойн тооцоо, төг					
Бэлчээрийн төлбөр	845	828	764	802	838
Сумын санд	135	135	135	135	135
МААЭС-д	365	365	365	365	365
МЧУС-д	345	328	264	302	338

Үр дүн: Малчдын орлого, бэлчээрийн төлбөр, байгалийн бүсээр

Үзүүлэлт	Өндөр уул	Ойт хээр	Хээр	Говь	Их нуурын хотгор
Өрхийн нийт орлого, мян төг	14163	16581	18664	14327	16392
Оны эхний 1 хонин толгойн орлого, мян төг	22.8	22.8	19.3	17.8	19.2
1 га-н орлого, мян төг	32.6	48.2	24.1	10	17.2
1 га-н төлбөр, төг	1253	1823	992	469	783
1 хонь-сарын төлбөр, төг	70	69	64	67	70
1 хонин толгойн төлбөр, төг	845	828	764	802	838
Бэлчээрийн 1 га-н суурь төлбөр	230	378	306	116	151
Бэлчээрийн даац ашиглалтын хувь	544	482	324	404	518
Бэлчээрийн 1 га– н суурь төлбөр 1 га-н орлогод эзлэх %	0.71	0.78	1.27	1.16	0.88
Бэлчээрийн 1 га-н төлбөр 1 га-н орлогод эзлэх %	3.84	3.78	4.12	4.69	4.55

Малын чанарын урамшууллын сан байгуулах үндэслэл

- ▶ Мал, махны бэлтгэлийн үндсэн дутагдал нь малчид зохион байгуулалтгүйгээс болоод боловсруулах үйлдвэр, хэрэглэгчидтэй шууд холбоглож чаддаггүй, ченжийн албан бус шат дамжлага үүсэж, ашгийн дийлэнх нь тэдэнд очдог
- ▶ Малчид мал, махыг хотноосоо, гараар нядлан борлуулдгаас чанарын баталгаагүй болдог, экспортод гаргаж чаддаггүй
- ▶ Стандартын шаардлагад нийцсэн хянан баталгаа хийгдэж чаддаггүй
- ▶ **Гарц:** Зах зээлд нийлүүлэх маханд гар нядалгааг бүрмөсөн халж, борлуулах малын бэлтгэл, гарал үүсэл, чанарын хянан баталгааг сумын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, “нэг сум-нэг хоршоо” гэсэн зарчмаар борлуулалтыг сумдад зохион байгуулах санхүүгийн эх үүсвэр бүрдүүлж, оролцогчдын оролцоог хангах эдийн засгийн хөшүүрэг болгоход малын чанарын урамшууллын санг ашиглах юм.

Бэлчээрийн төлбөрийг нэвтрүүлэх нь- Газрын төлбөрийн хуульд дараах өөрчлөлт оруулах:

8.1.1 Малчин өрхийг бэлчээр, хадлангийн газрын төлбөрөөс чөлөөлөх заалтыг **хүчингүй болгох**


Үүнтэй уялдуулан бусад хууль, журамд өөрчлөлт оруулах

Бэлчээрийн төлбөр татвар бус МАА-н үйлдвэрлэлийн зардал болох нь:

- Бэлчээрийн төлбөр нь одоогоор малчны хариуцахгүй байгаа МАА-н үйлдвэрлэлийн зардал болохыг дээр дурьдсан. Энэ нь бэлчээрийг ашигласны болон түүнд хохирол учруулсан бол тэр хэмжээгээр нийгэмд учирч байгаа зардал юм.
- Санал болгож арга зүйгээр дундаж малчин өрх жилдээ 524-739 мянган төгрөгийн төлбөр төлөх боловч 440-607 мянган төгрөг буюу 83 орчим хувийг буцаагаад авч байгаа тул бэлчээрийн төлбөр нь татвар бус, харин МАА-н орлогын тодорхой хэсгийг дахин хуваарилж, бэлчээрээ хамгаалж, сайжруулах, өвс тэжээл бэлтгэх, малын эрүүл мэнд, чанарт анхаарах зэрэг орон нутгийн МАА-н тогтвортой хөгжил, малчдын өөрсдийнх нь ашиг тусын тулд зарцуулах арга, хөшүүрэг юм. Ингэснээр:
 - Малчид малын тоог бус чанарт анхаарах, байгалийн эрсдэл тохиолдсон үед бусдын гар харахгүй бэлтгэлтэй болох
 - Сумын захиргаа бэлчээрийн менежмент, МАА-н эрсдэл, байгаль хамгаалах зэрэг төсвөөр хүлээсэн үүргээ чанартай биелүүлэх санхүүгийн эх үүсвэртэй болох юм.
- Малчин өрхөд ирж байгаа санхүүгийн нэмэлт ачаалал нь 1 хонин толгойд 135 төгрөг болж байгаа нь хүн амын орлогын татварыг 1 хонин толгойд 100 төгрөгөөр төлж байсан ачааллаас нэн бага юм. Учир нь энэхүү татвар үйлчилж байсан 2009 оноос хойш хэрэглээний үнийн индекс 1.9 дахин өссөн тул 2009 оны 100 төг одоогийн 190 төг-тэй тэнцэж байгаа нь 135 төг-өөс 40%-р өндөр байна.

Бэлчээрийн төлбөрийн талаар малчдаас авсан судалгааны дүн

ХХААХҮЯ-с судалгааг 21 аймгийн 12916 малчнаас 2018 оны 4-5 сард авсан.



Оролцогчдын эзлэх хувиар, %

Анхаарал тавьсанд баярлалаа